



Asian Development Bank

# ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР (ХХОАТ)



2023 он



# ГАРЧИГ

<b>1. ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР (ХХОАТ)</b> .....	4
1.1. ГАРЫН АВЛАГЫН ЗОРИЛТ .....	4
1.2. ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГО БА ХХОАТ .....	4
1.3. ХХОАТ-ЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ .....	5
1.4. ХХОАТ ТӨЛӨГЧ .....	6
1.5. ХХОАТ-ААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ ОРЛОГО .....	7
1.6. ХХОАТ-ЫН ХӨНГӨЛӨЛТ .....	7
1.7. ХХОАТ-ЫН ХЯЛБАРШУУЛСАН ГОРИМ .....	9
1.8. БИЧИЛ ХУДАЛДАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО .....	10
1.9. ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ .....	10
<b>2. ХХОАТ-ЫН БУЦААН ОЛГОЛТ</b> .....	11
<b>3. ХХОАТ-ЫН ЦАХИМ ТАЙЛАНГИЙН СИСТЕМ</b> .....	12

Хавсралт 1. Хувь хүний орлогын албан татвар ногдуулах хялбаршуулсан хүснэгт

# 1. ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР (ХХОАТ)

## 1.1. ГАРЫН АВЛАГЫН ЗОРИЛТ

Монгол улсад эдийн засаг, санхүү, бизнесийн харилцаа өргөжих тутам иргэдийн хувийн орлого, өмч хөрөнгө, тэдгээрийн эх үүсвэр, нэр төрөл улам өргөжиж байна.

Энэ нь Монгол улсын орон нутгийн төсвийн орлогын гол эх үүсвэр ХХОАТ-ыг хуулийн дагуу тэгш шударга ногдуулж хураах, нөгөө талаас татвар төлөгчдийн татвар төлөх үүрэг хариуцлагыг сурталчлан таниулах, эрсдлээс урьдчилан сэргийлэх шаардлагыг бий болгож байна.

Хувь хүмүүс татварын албаны цахим систем (e-tax.mta.mn, itax.mta.mn), татварын албаны бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг ашиглан татвар төлөгчөөр бүртгүүлэх, татварын ногдлоо алдаагүй, үнэн зөв тооцож, төлж тайлагнах таатай нөхцөл бүрдсэн ч татварын байгууллага нь ХХОАТ-ын бүтэц, зохион байгуулалт, ногдуулах аргачлал, зарчим, төлж тайлагнах үүргийг татвар төлөгчдөдөө байнга танилцуулах үүрэгтэй.

Иймд Монголын татварын албаны “Татварын боловсрол-2022” зорилтын хүрээнд татвар төлөгч хувь хүмүүст зориулсан энэхүү гарын авлагыг Азийн Хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр боловсруулан татвар төлөгчдөд толилуулж байна.



## 1.2. ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГО БА ХХОАТ

Хувь хүний орлогын албан татвар гэж төрөөс иргэн бүрд үнэ төлбөргүй хүргэж буй төрийн үйлчилгээ, тухайлбал боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, дэд бүтцийн бүтээн байгуулалт, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, батлан хамгаалах, орон нутгийн хөгжил зэрэг бүх нийтлэг үйлчилгээг санхүүжүүлэх зорилгоор хувь хүн бүрээс тэдгээрийн олсон орлогын хэмжээ, нэр төрөл, эх үүсвэр, татвар төлөх боломж, чадварт нь дүйцүүлэн тэгш, шударга байдлаар гаргуулах санхүүгийн механизм юм.

Монгол улсын Үндсэн хуулийн Арвандолоодугаар зүйлд “... Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн ... хуулиар ногдуулсан албан татвар төлөх ... үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ” гэж тодорхойлсон байдаг.

Хувь хүний орлогын хэмжээг түүний ажил, хөдөлмөр эрхлэлт, аж ахуйн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны дүнд бий болсон орлого, хөрөнгө, хуримтлал, хэрэглээний өсөлтийн хэмжээгээр тодорхойлдог.

Монгол улсын ХХОАТ-ын тухай хууль тогтоомж нь дэлхийн бусад улс орнуудын нэгэн адилаар дээрх нийтлэг зарчимд үндэслэгдсэн байдаг ба хүн бүр, жил бүр өөрийн олсон орлого, хөрөнгөө тайлагнаж, татвар ногдуулж төлөх үүрэг хүлээнэ.

Дээрх зорилтын хүрээнд Монгол улсын ХХОАТ-ын хуульд зааснаар хувь хүний дараах орлогод татвар ногдуулна.

1	2	3
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	Үйл ажиллагааны орлого	Хөрөнгийн орлого
4	5	6
Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого	Шууд бус орлого	Бусад орлого

### 1.3. ХХОАТ-ЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

ХХОАТ-ыг ногдуулж, төлж, тайлагнахад дор дурдсан хууль тогтоомж, эрх зүйн баримтуудыг мөрдлөг болгоно.

1	2	3
Хувь хүний орлогын албан татварын тухай хууль (2019)	ХХОАТ-ын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хууль (2019)	ХХОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлэх журам ( <i>Татварын ерөнхий газар (ТЕГ)-ын даргын тушаал, Дугаар А/261, 2019-12-30</i> )
4	5	6
Монгол улсад байнга оршин суугч татвар төлөгч болон оршин суугч бус татвар төлөгчийг тодорхойлох, бүртгэх, бүртгэлээс хасах, албан татварын тооцоо хийх журам ( <i>ТЕГ-ын даргын тушаал, Дугаар А/266, 2019-12-30</i> )	Татварын хялбаршуулсан горим ашиглах татвар төлөгчийн хүсэлтийг бүртгэх, шийдвэрлэх, бүртгэлээс хасах журам ( <i>ТЕГ-ын даргын тушаал, Дугаар А/259, 2019-12-30</i> )	Гадаад улсад ногдуулсан татварыг төлбөл зохих албан татвараас хасаж тооцуулах хүсэлт гаргах, баталгаажуулах журам ( <i>ТЕГ-ын даргын тушаал, Дугаар А/267, 2019-12-30</i> )
7		

ХХОАТ-аас хөнгөлөх нар, салхи, газрын гүний дулааны болон сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нүүрснээс хагас коксон түлш, хийн болон шингэн түлш гарган авах тоног төхөөрөмж, стандартад нийцсэн зуух, нам даралтын зуух, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуурын жагсаалт (*Засгийн газрын тогтоол, Дугаар 469, 2019-12-25*)

## 1.4 ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР ТӨЛӨГЧ

Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий дараах хувь хүн албан татвар төлөгч байна.



Монгол Улсын  
иргэн



Гадаадын  
иргэн



Харьяалалгүй  
хүн

Татвар ногдуулах зорилгоор албан татвар төлөгчийг Монгол Улсад байнга оршин суугч болон Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч гэж ангилна.

### Монгол Улсад байнга оршин суугч татвар төлөгч хувь хүн

- Үргэлжилсэн 12 сарын хугацаанд нийт 183 ба түүнээс дээш хоног Монгол Улсад оршин суусан
- Албан татвар ногдох орлогын 50 ба түүнээс дээш хувийг Монгол Улсад олсон орлого болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлого эзэлж байвал
- 12 сарын хугацаанд Монгол Улсад 183 ба түүнээс дээш хоногоор ажиллах нь хөдөлмөрийн гэрээ, эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлөөр нотлогдож байвал
- Гадаад улсад томилогдон ажиллаж байгаа Монгол Улсын төрийн албан хаагч
- Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй, түүнчлэн гадаад улсад олсон орлогод албан татвар ногдоно.

### Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч хувь хүн

- Үргэлжилсэн 12 сарын хугацаанд нийт 183-аас доош хоног Монгол Улсад оршин суусан хувь хүн
- Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн салбарт томилогдон ажиллаж байгаа гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүн
- Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод албан татвар ногдоно.

## 1.5. ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ ОРЛОГО

Дараах орлого ХХОАТ-аас чөлөөлөгдөнө:

- Хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж;
- Хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого;
- Гамшгийн үед олон улсын байгууллага, гадаад улсын Засгийн газар, хуулийн этгээд, иргэнээс Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд үзүүлж байгаа тусламж;
- Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/-ийн төлбөр, хүү, анз;
- Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан этгээд хоорондоо газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээгээ үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон орлого;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын орлого;
- Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн салбарт томилогдон ажиллаж байгаа гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүний цалин, нэмэгдэл, тэдгээрийн гэр бүлийн гишүүний гадаад улсад олсон орлого.

## 1.6. АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ

- Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хөнгөлөлтийн хэмжээ /төгрөгөөр/
0-6 000 000 хүртэл	240 000
6 000 000-12 000 000 хүртэл	216 000
12 000 000-18 000 000 хүртэл	192 000
18 000 000-24 000 000 хүртэл	168 000
24 000 000-30 000 000 хүртэл	144 000
30 000 000-36 000 000 хүртэл	120 000
36 000 000 ба түүнээс дээш	-


- Дээрх хөнгөлөлтөд үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого хамаарахгүй.
- Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн зөвхөн тухайн үйлдвэрлэлээс олсон дараах орлогод ногдуулах албан татварыг 50 хувиар хөнгөлнө:



Үр тариа



Төмс, хүнсний ногоо, түүний үр



Тэжээлийн ургамал



Модны суулгац



Жимс, жимсгэнэ, түүний үр, суулгац

- Монгол Улсын иргэн амьдран суух зориулалтаар ипотекийн зээлийн хөрөнгөөр хувьдаа, анх удаа орон сууц худалдан авсан бол албан татвар төлөгчид Монгол Улсын Засгийн газрын тодорхойлсон ипотекийн зээлийн хүүгийн дээд хэмжээ болон ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүү хоорондын зөрүүд төлсөн дүнтэй тэнцэх хэмжээний албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ.
- Монгол Улсын иргэн өөрийн албан татвар ногдсон орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар зөвхөн хувьдаа, анх удаа орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авсан бол ийнхүү орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авахад зарцуулсан хөрөнгөтэй тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг уг албан татвар төлөгчид эдлүүлэх бөгөөд энэ хөнгөлөлтийн хэмжээ 6 сая төгрөг хүртэл байна.



**6,000,000₮**  
**хүртэл**  
**хөнгөлөлт**



- Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд болон асран хамгаалагчаар тогтоогдсон асрамж, дэмжлэгт байгаа хүүхэд гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын сургуульд оюутан, эсхүл суралцагчаар элсэн суралцаж байгаа тохиолдолд түүний анхны бакалаврын болон дипломын мэргэжил эзэмших сургалтын хугацаанд тухайн татварын жилд төлсөн, баримтаар нотлогдож байгаа сургалтын төлбөртэй тэнцэх орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг эдлүүлнэ.

- Монгол Улсын иргэн суралцаж байх хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийн орлогоосоо албан татвар төлж, улмаар сургалтын төлбөр төлсөн их, дээд, мэргэжлийн болон техникийн боловсролын сургууль, коллежид анхлан суралцагч дээрх хөнгөлөлтөд хамруулна.



- Өөрийн хэрэгцээнд зориулан нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нүүрснээс хагас коксон түлш, хийн болон шингэн түлш гарган авах тоног төхөөрөмж, стандартад нийцсэн зуух, нам даралтын зуух, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур худалдан авсан бол баримтаар нотлогдож байгаа төлбөртэй тэнцэх тухайн жилийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг эдлүүлнэ.



- Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад зориулж өгсөн баримтаар нотлогдож байгаа хандивтай тэнцэх тухайн жилийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг албан татвар төлөгчид эдлүүлнэ.



- Донорын олговор, даатгалын нөхөн төлбөрт татварын хөнгөлөлт эдлүүлнэ.

- Монгол Улсын төрийн шагнал, Засгийн газрын шагнал, Монгол Улсын ардын болон гавьяат цолтны шагнал, шинжлэх ухааны нээлтийн шагнал.



- Аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар хөнгөлнө.

- Албан татварын хөнгөлөлтийг тайлагнаж төлсөн албан татварын дүнгээс хэтрүүлэн эдлүүлэхгүй.



## 1.7. ТАТВАРЫН ХЯЛБАРШУУЛСАН ГОРИМ

- Өмнөх жилийн албан татвар ногдох орлогын хэмжээ 50.0 сая төгрөгөөс хэтрээгүй нь тайлангаар баталгаажсан хувь хүн татварын хялбаршуулсан горимд шилжих тухай татварын албанд хүсэлт гаргана.
- Татварын хялбаршуулсан горим ашиглах татвар төлөгч нь татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон байна.
- Иргэн 12 дугаар сарын 31-ны дотор, ААН нь 3-р улиралд багтаан хялбаршуулсан горимд хамрагдах хүсэлт гаргана.
- Хялбаршуулсан горимоор татвараа төлж тайлагнахыг татварын албанаас зөвшөөрөл өгч татвар төлөгчид мэдэгдэнэ.
- Зөвшөөрөгдсөн тохиолдолд дараа оны 01 сарын 01-ээс эхлэн хялбаршуулсан горим ашиглана.
- Хялбаршуулсан горимд шилжсэн хувь хүний **жилийн орлогод 1 хувиар** татвар ногдуулна.
- Хялбаршуулсан горимд шилжсэн татвар төлөгч нь тухайн татварын жилд ногдох татвараа дараа оны 02 сарын 15-ны дотор төлнө.
- Ногдуулсан албан татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу НӨАТ суутган төлөгч болсон өдрөөс эхлэн татварын жилийн дундуур дээрх хялбаршуулсан горимоос гарна.

- Жилийн дундуур дараах үйл ажиллагаа эрхэлж эхэлсэн өдрөөс эхлэн хялбаршуулсан горимоос гарна:
  - Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах;
  - Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох;
  - Тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох;

Хялбаршуулсан горимоор албан татвар төлж байгаа хувь хүн бусад татварын хөнгөлөлт эдлэхгүй.

## 1.8. БИЧИЛ ХУДАЛДАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО

- Бичил худалдаа, ажил үйлчилгээ эрхлэгчийн орлогод ногдох татварыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр доор дурдсан хязгаарт багтаан тогтооно:
  - Ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүний хувьд албан татварын доод хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувь, дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээнд;
  - Хувиараа зорчигч, эсхүл ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүний хувьд албан татварын доод хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувь, дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээнд.

## 1.9. ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

Татварын хувь хэмжээ нь татвар төлөгчийн бүртгэл, татвар ногдох орлогын нэр төрлөөс хамаарч харилцан адилгүй байна.

Энэхүү гарын авлагын Хавсралт 1. Хялбаршуулсан хүснэгтээс үзнэ үү.

# 2.

## ХХОАТ-ЫН БУЦААН ОЛГОЛТ

- Албан татвар төлөгчийн татварын жилд төлсөн болон суутгуулсан ХХОАТ нь төлбөл зохих албан татварын хэмжээнээс давсан тохиолдолд илүү гарсан дүнг татварын илүү төлөлт гэнэ.
- Татварын ерөнхий хуулийн 49-р зүйлд зааснаар татварын алба нь татвар төлөгчийн илүү төлсөн татварыг дараах байдлаар шийдвэрлэнэ:

1	2	3
Буцаан олгох	Тухайн хугацаанд төлбөл зохих бусад татварт суутган тооцох	Татвар төлөгч зөвшөөрвөл дараагийн хугацаанд төлөх татварт суутган тооцох

- ХХОАТ-ын тухай хуулийн 28 дугаар зүйлд зааснаар буцаан олголтыг тухайн татварын албаны харьяалагдах засаг захиргааны нэгжийн төрийн сангийн дансаар дамжуулан албан татвар төлөгчид буцаан олгоно.
- Татварын алба жилийн тайлан хүргүүлэх хугацаанаас хойш ажлын 20 өдөрт багтаан буцаан олгох албан татварын хэмжээг хянан тодорхойлж, харьяалах төрийн сангийн нэгжид хүргүүлнэ;
- ХХОАТ-ын буцаан олголтыг дараа жилийн 2 дугаар улиралд багтаан олгоно.
- ХХОАТ-ын тайлан, илүү төлөлтийг цахим тайлангийн системд илгээж, баталгаажуулснаар буцаан авах эрх үүснэ.


# 3. ХХОАТ-ЫН ЦАХИМ ТАЙЛАНГИЙН СИСТЕМ

- ХХОАТ-ын цахим тайлангийн системд нэвтрэхийн тулд хувь хүн:

- <https://www.etax.mta.mn>



- <https://www.itax.mn>



Цахим холбоос дахь “Бүртгүүлэх” товч эсхүл “Татвар төлөгчөөр бүртгүүлэх” цэсээр дамжин татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

- Цахим тайлангийн системд татвар төлөгчөөр бүртгүүлснээр хувь хүн нь ХХОАТ болон бусад татварын тайланг цахим хэлбэрээр илгээх, татварын ногдол, төлөлтөө хянах буцаан олголт авах эрх, боломж үүснэ.
- ХХОАТ-ыг төлөх тайлагнах эцсийн хугацаа: Дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор

Зураг. Цахим тайлангийн системээр илгээсэн тайлангийн төлөв



ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ТАТВАРЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

### Хувь хүний орлогын албан татварын тайлангийн төлөв шалгах

	Тайлан	Төлөв	Тайлбар
1	ХХОАТ-ын тайлан	Шинэ	Шинээр тайлан гаргана
2	ХХОАТ-ын тайлан <i>/хадгалсан/</i>	Шинэ	Хадгалсан тайланг засварлаад илгээх шаардлагатай
3	ХХОАТ-ын тайлан	илгээсэн	Хэрэв хөнгөлөлт, буцаан олголтын тайлан бол шалгаж, дахин илгээх
4	ХХОАТ-ын тайлан	хуваарилагдсан	Татварын улсын байцаагчид хуваарилагдсан буюу шалгагдахаар хүлээгдэж байгаа
5	ХХОАТ-ын тайлан	хүлээж авсан	Татварын алба хүлээн авсан, тайлан баталгаажсан
6	ХХОАТ-ын тайлан	<b>ТТ-д буцаасан</b>	Тайлангийн мэдээлэл дутуу, шаардлага хангаагүй тул хүлээн аваагүй, засварлаж дахин илгээх шаардлагатай

Хавсралт-1: ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХЯЛБАРШУУЛСАН ХҮСНЭГТ

Албан татвар ногдох орлого (хуулийн заалтаар)	Татвар ногдуулах орлогыг тодорхойлох	Татварын хувь хэмжээ	Татварыг тодорхойлж, төсөвт төлөх	Төлөх хугацаа	Тайлагнах хугацаа
<b>I. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого</b>					
1	7.1.1. Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;	0-120 сая: 10%	Суутгагч	дараа сарын 10-ны дотор	Суутгагч улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
2	7.1.2. Ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого;		Суутгагч	дараа сарын 10-ны дотор	
3	7.1.3. Ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг;	120-180 сая: 12 сая дээр нэмэх нь 180 саяас дээш хэсгийн 15%	Суутгагч	дараа сарын 10-ны дотор	/Жилийн тайланг өссөн дүнгээр дараа оны 02 сарын 15-ны дотор/
4	7.1.4. Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;	180 саяас дээш: 21 сая дээр нэмэх нь 180 саяас дээш хэсгийн 20%	Суутгагч	дараа сарын 10-ны дотор	
5	7.1.5. Гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;		Суутгагч	дараа сарын 10-ны дотор	
6	7.1.6. Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;	(Орлого-ЭМ,НДШ)	Суутгагч	дараа сарын 10-ны дотор	
7	7.1.7. Хоол, унааны мөнгө;		Суутгагч	дараа сарын 10-ны дотор	

Албан татвар ногдох орлого (хуулийн заалтаар)	Татвар ногдуулах орлогыг тодорхойлох	Татварын хувь хэмжээ	Татварыг тодорхойлж, төсөвт төлөх	Төлөх хугацаа	Тайлагнах хугацаа
<b>II. Үйл ажиллагааны орлого</b>					
8	8.1.1. Бие даан эрхэлсэн мэргэжлийн ажил, үйлчилгээний орлого;	10%	Татвар төлөгч	дараа сарын 15-ны дотор	
9	8.1.2. Хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зуучлалын үйл ажиллагаа эрхэлж олсон орлого;	10%	Татвар төлөгч	дараа сарын 15-ны дотор	
10	8.1.3. Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл түүрвх, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого;	10%	Татвар төлөгч	дараа сарын 15-ны дотор	дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор
11	8.1.4. Эрхэлж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор үнэ төлбөргүй бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээ	10%	Татвар төлөгч	дараа сарын 15-ны дотор	
12	8.2. Тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг үйл ажиллагааны орлогод хамруулна.	10%	Татвар төлөгч	дараа сарын 15-ны дотор	
13	15.6. 50 сая төгрөгөөс доош борлуулалттай үйл ажиллагаа эрхлэгч, НӨАТ суутган төлөгч бус хувь хүний орлого	1%	Татвар төлөгч	дараа сарын 15-ны дотор	

Албан татвар ногдох орлого (хуулийн заалтаар)	Татвар ногдуулах орлогыг тодорхойлох	Татварын хувь хэмжээ	Татварыг тодорхойлж, төсөвт төлөх	Төлөх хугацаа	Тайлагнах хугацаа
<b>III. Хөрөнгийн орлого</b>					
14	9.1.1. Хөрөнгө ашиглуулсан болон түрээслүүлсний орлого;	10%	Татвар төлөгч	дараа сарын 15-ны дотор	дараа оны 02 сарын 15-ны дотор
15	9.1.2. Эрхийн шимтгэлийн орлого;	10%	Суутгагч	Дараа сарын 10-ны дотор	
16	9.1.3. Ногдол ашгийн орлого;	10%	Суутгагч	Дараа сарын 10-ны дотор	
17	9.1.4. Хүүгийн орлого.	10%	Суутгагч	Хүү олгох бүр	
18	21.5. Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагдах өрийн хэрэгсэл, хувьцаа, нэгж эрх эзэмшигч албан татвар төлөгчийн тухайн хувьцаа, нэгж эрх, өрийн бичигтэй холбоотойгоор олсон хүүгийн орлого, ногдол ашгийн орлого	5%	Суутгагч	Дараа сарын 10-ны дотор	дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
<b>IV. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого</b>					
19	10.1.1. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;	2%	Суутгагч	дараа сарын 10-ны дотор	дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
20	10.1.2. Газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;	10%	Татвар төлөгч	Дараа сарын 15-ны дотор	дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор
21	10.1.3. Хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;	10%	Татвар төлөгч	Дараа сарын 15-ны дотор	
22	10.1.4. Хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого;	10%	Татвар төлөгч <sup>5</sup>	дараа сарын 15-ны дотор	



Албан татвар ногдох орлого (хуулийн заалгаар)	Татвар ногдуулах орлогыг тодорхойлох	Татварын хувь хэмжээ	Татварыг тодорхойлж, төсөвт төлөх	Төлөх хугацаа	Тайлагнах хугацаа
<b>V. Шууд бус орлого</b>					
23	11.1.1. Үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн;				
24	11.1.2. Орон сууцны ашиглалтын болон түрээсийн зардлын төлбөр, байрын хөлс, түлшний зардлын төлбөр;				
25	11.1.3. Үзвэр үйлчилгээний олговор;				
26	11.1.4. Ахуйн үйлчлэгч, жолооч, цэцэрлэгч болон бусад үйлчилгээ үзүүлсний зардлын төлбөр;	0-120 сая: 10%			
27	11.1.5. Ажил олгогч, эсхүл бусад этгээдэд төлөх өр барагдуулсны төлбөр;	120-180 сая: 12 сая дээр нэмэх нь 180 саяас дээш хэсгийн 15%,	Суутгагч	дараа сарын 10-ны дотор	дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
28	11.1.6. Арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү;	180 саяас дээш: 21 сая дээр нэмэх нь 180 саяас дээш хэсгийн 20%			
29	11.1.7. Ажил олгогчийн төлсөн энэ хуулийн 11.2.7-д зааснаас бусад сайн дурын даатгалын хураамж;				
30	11.1.8. Гэр бүлийн гишүүний сургалтын төлбөр;				
31	11.1.9. Монгол Улсад нүүж ирэх болон буцахтай холбогдон гарах зардлын төлбөр;				
32	11.1.10. Эрс тэс уур амьсгалд ажиллаж амьдарсны нэмэгдэл;				
33	11.1.11. Дээрхтэй адилтгах бусад орлого.				

Албан татвар ногдох орлого (хуулийн заалтаар)	Татвар ногдуулах орлогыг тодорхойлох	Татварын хувь хэмжээ	Татварыг тодорхойлж, төсөвт төлөх	Төлөх хугацаа	Тайлагнах хугацаа
<b>VI. Бусад орлого</b>					
34	12.1.1. Урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого;	5%	Суутгагч	Дараа сарын 10-ны дотор	дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
35	12.1.2. Төлбөрт таавар, бооцоот толгоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлого;	40%	Суутгагч	Дараа сарын 10-ны дотор	
36	12.1.3. Бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого: ил задгай худалдаа үйлчилгээ эрхлэгчийн орлого	1%-50%	Эрх олгосон орон нутгийн нэгж	Тухай бүр	дараа оны 02 сарын 15-ны дотор
37	12.1.3. Бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого: зорчигч, ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгчийн орлого	5%-100%		Тухай бүр	
<b>VII . Оршин суугч бус этгээдийн орлого</b>					
38	20.1. Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлого	20%	Суутгагч	Дараа сарын 10-ны дотор	дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
39	20.3. Монгол Улсад хүрэлцэн ирж ажиллахтай холбогдон гарсан зардал	20%	Суутгагч	Дараа сарын 10-ны дотор	

*Тайлбар:*

*1. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч нь тухайн татварын жилд энэ хүснэгтийн 1-7, 15-17, 19, 23-35-р мөрөнд тодорхойлсон орлогыг гадаад улсад олсон бол дээрх хүснэгтэд заасан аргачлалын дагуу татвараа тодорхойлж дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор төлж, тайлагнана.*

*2. Үйл ажиллагааны орлого олж байгаа хувь хүний татвар ногдох орлогыг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Хасагдах зардлыг албан татвар төлөгч хувийн хэрэглээндээ зарцуулсан, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнээс өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулсан бол хасагдах зардлаар тооцохгүй. Үйл ажиллагаа эрхлэхэд ашиглаж байгаа машин, механизм, тоног төхөөрөмж, барилгыг гэр бүлийнхээ хэрэгцээнд нэгэн зэрэг ашиглаж байгаа бол ашиглалтын зардлыг хувь тэнцүүлэн тооцож хасагдах зардалд оруулна. Гэр бүлийн гишүүнд олгосон хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хэмжээтэй хувь тэнцүүлэн бодож хасагдах зардалд тооцно.*

*3. Энэ хүснэгтийн 18-р мөрөнд заасан татварын хувь хэмжээ нь оршин суугч болон оршин суугч бус этгээдэд нэгэн адил хамаарна.*

*4. Энэ хүснэгтийн 20-р мөрөнд заасан газар эзэмших ашиглах эрх борлуулсны орлогыг тодорхойлохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30.6-д заасан аргачлалыг баримтална.*

*5. Энэ хүснэгтийн 22-р мөрөнд заасан үнэт цаас, хувьцааг хамтран эзэмшиж байгаад борлуулсан бол татвар ногдуулах орлогыг тодорхойлсны дараа тухайн албан татвар төлөгчид ногдох хэсгийн үнийн дүнгээс татварыг тооцно.*

